

Д.Цэдэн-Иш, Т.Ариунаа, Б.Мөнхжаргал, Ч.Мөнхтуяа

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ I

Ерөнхий боловсролын сургуулийн
1 дүгээр ангийн сурах бичиг

Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамны
зөвшөөрлөөр хэвлэв.

Долоо дахь хэвлэл

СУРГУУЛИЙН НОМЫН САНД ОЛГОВ.
БОРЛУУЛАХЫГ ХОРИГЛОНО.

Улаанбаатар хот
2020 он

DDC
371.32
Д-782

Дүрслэх урлаг, технологи I: Ерөнхий боловсролын сургуулийн 1 дүгээр ангийн сурах бичиг / Цэдэн-Иш Д., ба бус; Ред. Нямсүрэн С. -УБ., 2014.-76х

Энэхүү сурах бичиг нь “Монгол Улсын Зохиогчийн эрх болон түүнд хамаарах эрхийн тухай” хуулиар хамгаалагдсан бөгөөд Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яамнаас бичгээр авсан зөвшөөрлөөс бусад тохиолдолд цахим болон хэвлэмэл хэлбэрээр бүтнээр эсвэл хэсэгчлэн хувилах, хэвлэх, аливаа хэлбэрээр мэдээллийн санд оруулахыг хориглоно.

Сурах бичгийн талаарх аливаа санал, хүсэлтээ textbook@mecs.gov.mn хаягаар ирүүлнэ үү.

© Боловсрол, Соёл, Шинжлэх Ухаан, Спортын Яам

ISBN 978-99973-69-53-6

ГАРЧИГ

Өмнөх үг.....5

I ХЭСЭГ

Дүрслэлийн хэрэглэгдэхүүнийг зөв ашиглах.....	6
Тосон харандааг зөв барьж, будаж сурах.....	8
Дүрс олшруулан будах.....	10
Өөрийгөө болон найзуудаа зурах.....	12
Цэгээр зурах.....	13
Дүрсийг толболох.....	15
Зургийг толболон чимэглэх.....	16
Зураасны төрөл ашиглан зурах.....	17
Нуман, долгион зураасаар зурах.....	19
Үргэлжилсэн зураасаар зурах.....	24
Зураг дүрслэлд дүрсийн нийлэмжийг ашиглах.....	25
Будаж сурах.....	26
Гүйцээж будах.....	28
Ижил дүрсийг олж зурж будах.....	29
Дүрсийг нэг өнгөөр зурах.....	30
Олон өнгөөр зурах.....	32
Нэг ба олон өнгөөр зурах.....	33
Шувуу зурах.....	36
Шүлгийн агуулгыг зургаар илэрхийлэх.....	38
Сурагчдын бүтээлээс наана цаана байгаа зүйлсийг нэрлэх.....	40
Өөрийн бодол төсөөллөөр зурах.....	41
Дуртай амьтнаа зурах.....	42

II ХЭСЭГ

Үндсэн таван дүрсийг бүтээх.....	44
Дарцаг хийх.....	46
Үндсэн дүрсээр наамал хийх.....	48
Үндсэн дүрсийг зохиомжлон наах.....	49
Дүрс зохиомжлон үхэр наах.....	50
Дүрс зохиомжлон амьтан наах.....	51
Дүрс зохиомжлон аяганы суурь хийх.....	52
Цаасан чимэглэл хийх.....	53
Мэндчилгээний загвар хийх.....	54
Загварчлан бүтээх.....	56
Үндсэн дүрсээр загвар бүтээх.....	57
Цаасыг нугалж хайчлах аргыг ашиглах.....	59
Цаасыг нугалж хайчлах аргаар тоглоом хийх.....	61
Цаасыг нугалж хайчлах аргаар машин бүтээх.....	63
Амьтны загвар хийх.....	64
Цаас нугалж бүтээл хийх.....	65
Навчаар урлах.....	69
Баримлын шавраар урлах.....	71
Чэгтэн хээг баримлын шавраар хийх.....	73
Ашигласан ном	75

Таних тэмдгүүдийг сурагчдад сайн ойлгуулаарай.



Мэдээлэл



Санамж



Сурагчийн үйл
ажиллагаа



Тайлбарлах, ярилцах,
унших



Сонгох дадлагын
ажил



Даалгавар

ӨМНӨХ ҮГ



Хүүхдүүд ээ! Та бүхэн хамгийн их зурах, будах, бүтээх дуртай номтойгоо танилцаж байна.

Балын харандаа ба тосон харандаа, бийр, цаасны хайчийг зөв барьж сурна. Энгийн дүрс зурахдаа цэглэх, толболох, төрөл бүрийн зураасыг ашиглана. Өөрийн бодол төсөөллөөр зурна. Үндсэн дүрсийг хайчлах, эвлүүлэн наах, нугалах, баримлын шавраар барих аргаа амьтны ба техникийн загвар бүтээнэ.

Та нар эдгээр сонирхолтой дасгалыг хийж сурснаар аливааг урнаар сэтгэх, ургуулан бодох зэргээр оюун ухаанаа хөгжүүлэх болно.

ДҮРСЛЭЛИЙН ХЭРЭГЛЭГДЭХҮҮНИЙГ ЗӨВ АШИГЛАХ



Балын харандааг зөв барьж зурах




1.1 дүгээр зураг. а Зүүн, б Баруун гарын зөв барилт




1.2 дугаар зураг. Баллуурыг нэг чиглэлд татаж баллуурдах




1.3 дугаар зураг. Харандааг эрхий болон бусад хуруунуудаараа дамнуулан барьснаар зураасыг чөлөөтэй зурахад хялбар



1.4 дүгээр зураг. Зураасыг хэвтээ болон босоо чиглэлд зурах



1.5 дугаар зураг. Зураасыг ташуу чиглэлд зурах



1.6 дугаар зураг. Нуман зураасыг гүйцээж зурах




Дэвтэртээ гүйцээж зураарай.




1.7 дугаар зураг. Жимсний зургийг гүйцээж зураад будаарай




Эсгий бал (Фломастер)-аар ташуу, хэвтээ, босоо чиглэлд зураас зурах




1.8 дугаар зураг. Яргуй цэцэг зурааслах




1.9 дүгээр зураг. Цэцэг зураасална уу



1.10 дугаар зураг. Байшин зураасална уу




1.11 дүгээр зураг. Дэвтэртээ гүйцээж зурах



Нэг мөрөнд дэвтэртээ гүйцээж зураарай.

ТОСОН ХАРАНДААГ ЗӨВ БАРЬЖ, БУДАЖ СУРАХ



1.12 дугаар зураг. а Зүүн б Баруун гарын зөв барилт

Шохойн харандаа нь хуурай шохойн, тосон, лааны тосон гэсэн гурван төрөл байдаг.



Тосон харандаа






Хуурай шохойн харандаа






Лааны тосон харандаа



1.13 дугаар зураг. Тосон харандаан дүрслэл



1.14 дүгээр зураг. Дүрсүүдийг заасан чиглэлийн дагуу будаарай.



1.15 дугаар зураг. Дүрсүүдээс сонгон тосон харандаагаар будаарай.



ДҮРС ОЛШРУУЛАН БУДАХ



1.16 дугаар зураг. Дүрсийг нугалаа үүсгэн ялган олшруулж өнгө будах



1.17 дугаар зураг. Сурагчдын бүтээлээс



1.18 дугаар зураг. Гурвалжин дүрс нугалаа үүсгээд өнгө ялган олшруулан будаарай.



1.19 дүгээр зураг. Сурагчдын бүтээл

ӨӨРИЙГӨӨ БОЛОН НАЙЗУУДАА ЗУРАХ



- Зургийг ажиглаарай.
- Зурагт юу юу дүрсэлснийг нэрлээрэй.
- Өөрийн бодол төсөөллөөр зургийн утга санааг тайлбарлаарай.






1.20 дугаар зураг. Э.Тулга, нас 6. Найзууд, 2013. 21x29. Цаас, тосон харандаа.



1.21 дүгээр зураг. Ц.Отгонцэцэг, нас 6. Найзууд, 2013. 21x29. Цаас, тосон харандаа

ЦЭГЭЭР ЗУРАХ



1.22 дугаар зураг. Цэгээр зурах


1




2



3



4



1.23 дугаар зураг. Дэгдээхэй зурж будаарай.



Дэгдээхэйг цэгээр зураарай.




1.24 дүгээр зураг. Навч зурах арга



1.25 дугаар зураг. Цэцэг зурах арга



1.26 дугаар зураг. Гөлөг зурах




1.27 дугаар зураг. Дэвтэртээ дөрвөн алим зурж өөр өөр өнгөөр будна уу.

ДҮРСИЙГ ТОЛБОЛОХ



1.28 дугаар зураг. Мөөг толболох



1.29 дүгээр зураг. Үхэр толболох



Цэг хэмжээнээсээ хальж томрохыг толбо гэдэг.



1.30 дугаар зураг. Толбо үүсгэх




Бөмбөлөг зурж толбоор чимэглэнэ үү.

ЗУРГИЙГ ТОЛБОЛОН ЧИМЭГЛЭХ



1.31 дүгээр зураг. Анааш толболох



1.32 дугаар зураг. Б.Гэгээндарь. нас 8.
Цох хорхойн хурал. 2010. Усан будаг



Хуруундаа будаг түрхээд цаасан дээр дарж амьтан болгон зураарай.

ЗУРААСНЫ ТӨРӨЛ АШИГЛАН ЗУРАХ



Урт
Богино
Өргөн
Нарийн зураас байж болно.

1. Шулуун




2. Тахир



1.33 дугаар зураг. Шулуун ба тахир зураас



1. Шулуун зураасаар юу дүрсэлж болох вэ?



1.34 дүгээр зураг. Шулуун зураасаар зурсан дүрсүүд


2. Тахир зураасыг яаж үүсгэх вэ?




1.35 дугаар зураг. Шулуун зураасаар тахир зураас үүсгэсэн байдал.




Дэвтэртээ тахир зураас бүхий мод зураарай.



1.36 дугаар зураг. Тахир зураасаар зурсан уул.



1.37 дугаар зураг. Тахир зураасаар зурсан мод



1.38 дугаар зураг. Шулуун ба тахир зураас оролцуулан зурсан байшин



Шулуун болон тахир зураасаар дүрс зохиож будна уу.

НУМАН, ДОЛГИОН ЗУРААСААР ЗУРАХ



Зураасыг дуурайлган зураарай.




1.39 дүгээр зураг. Нуман зураас

1.40 дүгээр зураг. Долгион зураас



1.41 дүгээр зураг. Нуман зураасыг дэвтэртээ зурна уу.






1.42 дугаар зураг. Нуман зураасаар навч, бөмбөлөг зураарай.



Өөрийн сонирхдог цэцгээ зурж хэдэн нуман зураас орсныг тоолоорой.



1.43 дугаар зураг. Нуман зураас



1.44 дүгээр зураг. Долгион зураас




Долгион зураасыг дуурайлган зурна уу.



1.45 дугаар зураг. Долгион зураас




Нуман ба долгион зураасны ялгааг зурж үзүүлээрэй.



1.46 дугаар зураг. Амьтны толгой зурах

1. Ямар нэртэй зурааснууд орсон байна вэ?




Ээдрээт яргуй.

Айргана.

Сараана.


2. Нэг цэцгийг сонгон зурж будна уу.




1.47 дугаар зураг. Ээдрээт яргуй, айргана, сараана цэцэг. Цэцэг тус бүрт ямар зураас хэд орсныг тоолоорой.




Байшин



Байшинд хэдэн шулуун зураас орсныг тоолоорой.




Байшин зурахад хэдэн тахир зураас орсныг тоолоорой.



Энэ хоёр цонхонд хэдэн тахир зураас орсныг тоолоорой.

1.48 дугаар зураг. Байшин зурах




1.49 дүгээр зураг. Хүүхдүүд ээ, өөрсдөө хөшигний хээ зохиож зураарай.

ҮРГЭЛЖИЛСЭН ЗУРААСААР ЗУРАХ



Сурагчид сонирхсон дүрсүүдээ зурна. Түүнийг тойруулан тасралтгүй нэг зураасаар зурна уу.





1.50 дугаар зураг. А цэгээс эхэлж үргэлжилсэн зураас.



1.51 дүгээр зураг. Үргэлжилсэн зураас. Үргэлжилсэн зураасан зургаас сонгон зурж болно. Эсвэл өөрөө зураг зохиож зураарай.


ЗУРАГ ДҮРСЛЭЛД ДҮРСИЙН НИЙЛЭМЖИЙГ АШИГЛАХ



1.52 дугаар зураг. Зураг дээр ямар дүрсүүд байна вэ?



1.53 дугаар зураг. Байшин



1.54 дүгээр зураг. Гэр



1.55 дугаар зураг. Байшин зурах




1.56 дугаар зураг. Гэр зурах


БУДАЖ СУРАХ




1.57 дугаар зураг. Бийрний үснээс хойш 3-4 хурууны зайтай зөөлөн барина.



1. Будаг найруулах нийлүүр.



2. Найруулсан будгийг тараан буддаг.



3. Бийрний үсийг чанга дарахгүй, өмнөх будгаас залгуулан татаж будна.



4. Будаг дууссан байдал


Бийрээ усанд орхиж болохгүй



1.58 дугаар зураг. Будах арга






Дэвтэртээ гурван дөрвөлжин зурж тус бүрийг нь өөр өнгөөр будаарай.



1.59 дүгээр зураг. Өөрийн дуртай улирлын тэнгэр, газрыг зурж усан будгаар будаарай.




Бийрийг хажуугаар нь тавих юмуу эсвэл үсийг дээш харуулж ишээр нь саванд хийж хадгална.



1.60 дугаар зураг. Дүрсүүдийг зургийн дэвтэртээ зурж будаарай.

ГҮЙЦЭЭЖ БУДАХ




1.61 дүгээр зураг. Шувуу

Шувуу хуулж зураад будна уу.



1.62 дугаар зураг. Дэвтэртээ шувууг зураад гүйцээж будаарай.

ИЖИЛ ДҮРСИЙГ ОЛЖ ЗУРЖ БУДАХ



1.63 дугаар зураг. Эрвээхэй

Таван ижил эрвээхэйг олж дэвтэртээ зураад будна уу.







1.64 дүгээр зураг. Цэцэгс

Бүтнээрээ харагдах таван сараана цэцгийг дэвтэртээ хуулж зурж, будаарай.



ДҮРСИЙГ НЭГ ӨНГӨӨР ЗУРАХ

Өөрийн сонирхсон өнгөөр будах




1.65 дугаар зураг. Дүрс зурах.
Зурагнуудаас сонирхсон дүрсээ сонгон зурна. Зургийн ар талыг өөрийн дуртай өнгөөр будаарай.



Нэг өнгөөр юу юу зурсан бэ?



1.66 дугаар зураг. Б.Хулан, нас 7. Далай, 2013. 21x29. Цаас



1.67 дугаар зураг. Цэнхэр өнгөтэй үүл ба яргуй



Ягаан өнгөтэй цэцэг навч зурна уу.

ОЛОН ӨНГӨӨР ЗУРАХ



Олон өнгөөр зурсан зураг нэг өнгөөр зурсан зургаас илүү сайхан харагддаг.

1.68 дугаар зураг. М.Марал, нас 6. Жимс, 2013. 21x29. Цаас, тосон харандаа



Гурван өөр өнгө ашиглан юу зурж болохыг ярилцаж бүтээл хийгээрэй.



О.Бэрцэцэг, нас 7. Оройн хоол. 2013. 21x29. Цаас, усан будаг.



Б.Хүслэн, нас 7. Тогос, 2013. 21x29. Цаас, усан будаг.



Т.Ариунбилэг, нас 7. Буга, 2013. 21x29. Цаас, усан будаг.



1.69 дүгээр зураг. Гурван өөр өнгө ашиглан зурсан зургууд

Нэг ба олон өнгөөр зурсан зургийн аль нь таалагдаж байгааг харьцуулан ярилцаарай.

НЭГ БА ОЛОН ӨНГӨӨР ЗУРАХ



1.70 дугаар зураг. Цэцэгсийг ажиглаарай.

1.71 дүгээр зураг. С.Есөнзаяа нас 7. "Ваартай цэцэг" 2012. 21 x 29 см. Усан будаг



1.72 дугаар зураг. Ч.Баярчимэг нас 7. "Хонхон цэцэг" 2012. 21 x 29 см. Усан будаг





Өөрийн үнэлгээ: Цэцэг ургуулахад 2.32 дугаар зураг дээрх зүйлээс аль нь хэрэгтэй вэ?



1.73 дугаар зураг.



Ангидаа болон гэртээ байгаа тасалгааны ургамлын нэрийг мэдэж ирээрэй.



1.74 дүгээр зураг. Дэвтэртээ намуу цэцэг нэг өнгөөр зурна уу.



1.75 дугаар зураг. Намуу цэцэгс

Намуу цэцэг нь 20-80 см хүртэл өндөр ургадаг.



1.76 дугаар зураг. Цэцгийн ямар өнгөөр зурсан бэ?



Найзыгаа зураад дуртай зүйлийг нь зурж нэрлэнэ үү.

- Юуг тод томруун зурсан бэ?
- Юу юуг жижиг зурсан бэ?
- Зургийн утга санааг илэрхийлээрэй.




1.77 дугаар зураг. Э.Оюун-Эрдэнэ, нас 7. Миний найз. 2013. 21x29. Цаас, усан будаг




Бүтээлээ бусдадаа тайлбарлаарай.


ШУВУУ ЗУРАХ



1.78 дугаар зураг. Сонирхсон аль нэг дэгдээхэйг зурж будна уу.



1.79 дүгээр зураг. Сонирхсон шувуугаа хуулж зураад будаарай.




1.80 дугаар зураг. Нэг шувуу сонгож зураад будна уу.



Гэрийнхэндээ шувуу зурж үзүүлээрэй.



1.81 дүгээр зураг. Тогорууны бодит зураг



1.82 дугаар зураг. Тогоруу

Тогорууны хөдөлгөөнийг ажиглана уу.



Өөрийн хамгийн сайн мэддэг шувуугаа зурж будаарай.

ШҮЛГИЙН АГУУЛГЫГ ЗУРГААР ИЛЭРХИЙЛЭХ



Шүлгийг уншаад, сурагчдын бүтээлийг сонирхоорой.

Миний дээл

Ээжийн оёсон шинэхэн дээл
 Эвсээрхэн хөнгөн хөөрхөн дээл
 Дээл эмжээр нь зохисон дээл
 Товч шилбэ нь тохирсон дээл
 Тоос шороонд хөрвөөмгүй дээл
 Тос өөхөнд шүргэмгүй дээл
 Хийсэн эд нь хэврэг байг
 Хийлгэсэн эзэн нь хийморьлог яваг гэж
 Ачит ээжийн минь ерөөсөн дээл
 Айлын эгчийн мялаасан дээл



Т.Жамъяансүрэн



О.Сүлд, нас 6, Миний дээл, 2014. 21x29. Цаас, тосон харандаа.



3.Оюундарь, нас 6, Миний дээл, 2014. 21x29. Цаас, тосон харандаа.

1.83 дугаар зураг. Сурагчдын бүтээл



Миний дээл шүлгийн агуулгыг зургаар илэрхийлнэ үү?



Онъсогыг таагаарай.

“Түнтгэр өвгөн Түмэн жадтай” тэр юу вэ?




1.84 дүгээр зураг. Б.Анударь, нас 6, Зараа, 2014. 21x29. Цаас, тосон харандаа.

Шүлгийг цээжлээд зараа зураарай.

ЗАРАА

Хамгийн хөөрхөн амьтан
 Хаана амьдардаг вэ? гэж
 Эрэгт амьдардаг зараанаас
 Эрхэм загас асуужээ.
 Миний үрээс энхрий
 Мяндал зөөлөн амьтан
 Энэ хорвоод байхгүй гэж
 Ээж зараа хариулжээ.

О.Сундуй



1.85 дугаар зураг. Зараа зурах дараалал



Зараа шүлгийн агуулгыг зургаар илэрхийлэн зурна уу.

СУРАГЧДЫН БҮТЭЭЛЭЭС НААНА ЦААНА БАЙГАА ЗҮЙЛСИЙГ НЭРЛЭХ



Сурагчдын бүтээлд юу юу дүрсэлсэн болохыг нэрлээрэй. Зурсан зурагт наана, цаана юу дүрсэлснийг нэрлээрэй. Өөрийн бодол төсөөллөөр зураг зураарай.



1.86 дугаар зураг. М.Номин, нас 7. Ажилч хулгана. 2010. 21 x 29 см. Усан будаг



1.87 дугаар зураг. С.Есөнзаяа, нас 7. Уралдсан нь. 2012. 21 x 29 см. Усан будаг



1.88 дугаар зураг. М.Номин, нас 7. Анар ах. 2011. 21 x 29 см. Усан будаг



1.89 дүгээр зураг. О.Сүндэр, нас 6. Маша охин. 2013. 21 x 29 см. Усан будаг

ӨӨРИЙН БОДОЛ ТӨСӨӨЛЛӨӨР ЗУРАХ



1.90 дүгээр зураг. Талбай дээр зурах ч гоё шүү.



1.91 дүгээр зураг. Өнгийн цаасан дээр эсгий балаар зурсан зураг.



1.92 дугаар зураг. Баримлын шавар дээр зурлаа.

Зургийг даавуу, чулуу, баримлын шавар, цаас зэрэг олон зүйл дээр зурж болдог.



1.93 дугаар зураг. Чулуун дээр зураас арилгагч болон тосон харандаагаар зурсан зураг.



1.94 дүгээр зураг. Даавуун дээр эсгий балаар зурсан зураг.



Өөрийн сонирхсон зүйлээ баримлын шавар дээр зурж үзээрэй.


ДУРТАЙ АМЬТНАА ЗУРАХ



Амьтан яаж зурсныг ажиглаж ярилцаарай.



1.95 дугаар зураг. Б.Хүслэн, нас 6. Арслан. 2013. 21 x 29 см. гуаш



1.96 дугаар зураг. Э.Энхтөр, нас 7. Бар. 2013. 21 x 29. гуаш

Амьтад зурна уу.



1.97 дугаар зураг. Б.Баттулга, нас 5. Уяан дээрх зочин. 21 x 41 см. Үзгэн бал



Заан



Зараа

1.98 дугаар зураг. Амьтны зураг



Гавар



Үнэг



Хэрэм



Янзага



Бамбарууш



Торой

1.99 дүгээр зураг. Сонгон зурах амьтад



1.100 дугаар зураг. М.Мөнх-Оргил, нас 6. Тэмээчин. 2010. 25 x 25 см. Гуаш



1.101 дүгээр зураг. Л.Базарсад, нас 7. Нүүдэл. 21 x 29 см. Гуаш, эсгий бал



Зурсан амьтнаа будаарай.

ҮНДСЭН ТАВАН ДҮРСИЙГ БҮТЭЭХ



Дүрс хэрхэн бүтдэг вэ? Туршиж үзээрэй.




Ам дөрвөлжин



Дугуй



Гурвалжин




Зууван дугуй



Гонзгой дөрвөлжин

2.1 дүгээр зураг. Үндсэн дүрс

Хэрэглэгдэхүүн: Үндсэн дүрсүүд, чулуу, савх мод, өнгийн цаас, хайч, харандаа



зурах



хайчлах




эвлүүлэх



өрөх

2.2 дугаар зураг. Дүрс үүсгэх арга

Үндсэн таван дүрсээр зурагт юу дүрсэлснийг нэрлээрэй.



2.3 дугаар зураг. Үндсэн дүрс ба биет



Дугуй дүрс зурж, тосон харандаагаар будаарай.



1. Дугуй дүрс




2. Зурааснаас давуулахгүй, дутаахгүй, дуртай өнгөөрөө будна.



3. Будгийг бэхжүүлж цаасны цавуу жигд түрхэнэ.


2.4 дүгээр зураг. Дугуй дүрс будах



2.5 дугаар зураг. Үндсэн дүрсийг гүйцээж зураад будаарай.



Зурагт орсон үндсэн дүрсүүдийг тоолоод зурж тэмдэглэнэ үү.



2.6 дугаар зураг. Байшин зурж будах

ДАРЦАГ ХИЙХ




Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас, харандаа хайч, бичгийн цавуу, савх мод

Дарцаг хийх



1. Улаан өнгийн цаасыг нугалаад нэг хэсгийг нь цавуудна.



2. Нугалсан цаасанд дарцгийн савх модыг хавчуулаад цаасаа нийлүүлэн наагаарай.



3. Дарцгийн хоёр талд хөх өнгийн цаас наана.

2.7 дугаар зураг. Дарцаг хийх


1. Дарцгаа олон хэлбэрт оруулан хайчилж туршаарай.
2. Дарцаг дээр дуртай зүйлээ зурж чимэглэнэ үү.



2.8 дугаар зураг. Өнгө өнгийн олон хэлбэртэй дарцаг хийгээрэй.



Санамж: - - - - - (тасархай) зураасын дагуу хайчилна.



2.9 дүгээр зураг. Дарцаг хийх загвар



Олон дарцаг хийж ангиа чимэглээрэй.



2.10 дугаар зураг. Дарцагууд

ҮНДСЭН ДҮРСЭЭР НААМАЛ ХИЙХ



2.11 дүгээр зураг. Далайн эрэг дээр байшин наах



Наамал хийхдээ:
Авчирсан зураг дээрээ байшингийн наамал хийнэ.



Байшингийн наамал хийж сонирхоорой.



2.12 дугаар зураг. Миний байшин



Наамал хийхдээ:
Байгалийн зураг дээр гэрээ хаана нь наах вэ?




2.13 дугаар зураг. Тал дээр гэрийн зураг наах


ҮНДСЭН ДҮРСИЙГ ЗОХИОМЖЛОН НААХ



Цэцэг хийгээрэй.



2.14 дүгээр зураг. Боролзгоно цэцэг



2.15 дугаар зураг. Навч



2.16 дугаар зураг. Боролзгоно цэцэг



2.17 дугаар зураг. Лийр зурах

ДҮРС ЗОХИОМЖЛОН ҮХЭР НААХ



1. Дөрвөлжин цаас хоёр ширхгийг бэлтгээд суурь цаасан дээр наана.



2. Ам дөрвөлжин цаасыг дөрвөн тэнцүү нугална. Нугалаасны дагуу хайчилна.

Хэрэглэгдэхүүн:
Өнгийн цаас, хайч, цавуу



3. Хайчилсан цаасаар үхрийн чих, сүүл, хөл нааж хийнэ.



4. Өнгийн цаасаар үхрийн эвэр, нүд, хамар нааж болно.

2.18 дугаар зураг. Дүрс эвлүүлэн үхэр наах



Хүүхдүүд ээ! Үхэр хийсэн аргаар өөр ямар амьтан хийж болохыг туршаарай.


ДҮРС ЗОХИОМЖЛОН АМЬТАН НААХ



Ертөнцийн гурван хөөрхөн

Бой нь арилсан хүүхэд нэг хөөрхөн
Борвио нээсэн гөлөг нэг хөөрхөн
Босож тэнцэж байгаа ботго нэг хөөрхөн


Гөлөг хийх аргачлал:



1. Ам дөрвөлжин цаасыг зураасны дагуу хуваана.



2. Хуваасан цаасаа нааж гөлөгний толгой, их биеийг гаргана.



3. Ам дөрвөлжин цаасыг 2 нугалж 4 ширхэг гурвалжин дүрс хайчлан бэлтгэнэ.




4. Хоёр чих, хөлийг гурвалжин дүрсээр наана.



Ц.Энхжин. нас 7
Туулай. 2013.
Цаас



Э.Аранжин. нас 6
Эрвээхэй 2013. Цаас



5. Нүд, амыг цаасаар хийнэ.

2.19 дүгээр зураг. Сурагчдын бүтээл

ДҮРС ЗОХИОМЖЛОН АЯГАНЫ СУУРЬ ХИЙХ



Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас, хайч, цавуу 12 см х 2 см 14 ширхэг туузан цаас бэлтгэнэ.


Хоёр өнгийн туузан цаас тус бүр 7 ширхэг байна.



1. Хоёр өөр өнгийн цаасны үзүүрийг давхарлан наана.



2. Цаас сүлжиж наагаарай.



3. Туузан цаасаа тэгшхэн барьж наана.



4. Туузан цаасан сүлжмэл.

2.20 дугаар зураг. Цаасан сүлжмэл хийх арга

ЦААСАН ЧИМЭГЛЭЛ ХИЙХ



Хэрэглэгдэхүүн: Улаан өнгийн туузан цаас 4 ширхэг, ногоон өнгийн цаас, хайч, ногоон өнгийн цаас.



1. Туузан цаасыг дугуйруулан наана.



2. Хоёр дахь туузан цаасыг мөн дугуй хэлбэрт оруулан наана.



3. Гурав ба дөрөв дэх туузан цаасыг наахад алимны дүрс үүснэ.



4. Ногоон өнгийн цаасаар навч хайчилна. 5. Туузан цаасан алим.



2.21 дүгээр зураг. Алим хийх



Үүлийг цагаан ба цэнхэр өнгийн цаасаар наана уу.



Цаасан чимэглэл хийгээрэй.

2.22 дугаар зураг. Сонгон хийх дадлагын ажил

МЭНДЧИЛГЭЭНИЙ ЗАГВАР ХИЙХ



Баярын мэндчилгээ урлаж хайртай ээж, аав, ах дүү, найз нөхдөдөө дурсгаарай.



1. Цаас голоор нь нугалж дээр нь цэцэг навч зураад хайчилна.

2. Хайчилсан цэцгийг дөрвөлжин цаасан дээр наана.

3. Ээждээ мэндчилгээ бичээрэй.

2.23 дугаар зураг. Цаасан мэндчилгээний загвар

Найздаа төрсөн өдрийн баяр хүргээрэй.



Мэндчилгээний дотор талын хэсэг



Нүүрэн тал



1. Хэв ашиглан дугуй зурж, хайчилна.

2. Дугуй дүрсэн дотроо зураг зурж чимэглээрэй.

3. Туузан цаасны үзүүрийг холбон наана.

4. Туузаа цаасны голд наана.



Шинэ оны мэнд



Шинэ оны мэнд

5. Мэндчилгээний үгээ гоё сайхан бичээрэй.

2.24 дүгээр зураг. Цаасан мэндчилгээний загвар

ЗАГВАРЧЛАН БҮТЭЭХ





Хүүхэлдэйн баатар загварчлан бүтээх аргачлал:



а) Зууван дугуй дүрс хайчилна



б) Зууван дугуй дүрс дээр нүд, ам зурна.




в) 20 см урттай 2 ширхэг, 30 см урттай 2 ширхэг цаас бэлтгэнэ.



г) Гонзгой дөрвөлжин цаасыг нааш цааш нугалж гар хөл наана.



д) Наасан хөл гарт зууван дугуй дүрс наана.



2.25 дугаар зураг. Хүүхэлдэйн баатар загварчлах арга

ҮНДСЭН ДҮРСЭЭР ЗАГВАР БҮТЭЭХ



Автобус бүтээх



Сургуулийн машин хийх аргачлал:



1. 15X8см цаасаар автобусны их бие хийнэ.



2. Автобусанд дугуй хийнэ.



3. Багш, сурагчдыг цагаан цаасан дээр зурж цонхонд наана.


2.26 дугаар зураг. Сурагчид зорчих тээврийн машин бүтээх



Сонгож хийх даалгавар:



Суудлын машин



Усан онгоц

2.27 дугаар зураг. Сонгон хийх даалгавар



Дууг дуулж сураарай.

О.Энхбаатарын шүлэг

Сансрын нисэгч

Сансрын нисэгч ах аа
 Сайн яваад ирэв үү
 Саран наран хоёртой
 Саадгүй учраад ирэв үү
 Санасан хэргээ бүтээгээд
 Сурсан эрдмээ гийгүүлээд
 Сайхан үйлсийн төлөө
 Самбаа сориод ирэв үү
 Огторгуйн нисэгч ахаа
 Олзтой яваад ирэв үү.
 Од мичдийн орноор
 Оройн нарыг үзэв үү
 Онцгой томилолт аваад
 Оддын хотхонд очоод
 Сайхан үйлсийн төлөө
 Самбаа сориод ирэв үү



Сансрын хөлөг хийцгээе.




1. Гурвалжин дүрсээр сансрын хөлөг наагаарай.




2. Сансрын нисэгч зурж наагаарай.

2.28 дугаар зураг. Сансрын хөлөг



Усан доогуур шумбагч онгоц




Галт тэрэг

2.29 дүгээр зураг. Сонгож хийх ажил



ЦААСЫГ НУГАЛЖ ХАЙЧЛАХ АРГЫГ АШИГЛАХ



1. Ам дөрвөлжин цаасыг голоор нь нугална.



2. Битүү талд нь лийрээ зурна.



3. Лийрийн зургаа дэлгээрэй.

2.30 дугаар зураг. Лийр




Сонгож хийх дадлагын ажил: Цаас нугалан хайчилж олон ургамал, амьтан бүтээж сураарай.



Яргуй цэцэг



Навч



2.31 дүгээр зураг. Цэцэг навч



Загас




Алим




2.32 дугаар зураг. Загас, алим




Бөмбөлөг хайчилж сонирхолтой бяцхан ном хийх аргачлал



1. Ам дөрвөлжин цаасыг голоор нь нугална.



2. Бөмбөлөг зураад хайчилна. Тасархай зураас харагдахгүй байгаа хэсгийг хайчилж болохгүй шүү.



3. Хайчилсан бөмбөлгөө дэлгээрэй. Холбоотой хоёр бөмбөлөг үүснэ.



4. Дахин өөр өнгийн цаас нугалж бөмбөлөг зураад хайчлаарай.




5. Дуртай хүүхэлдэйн баатруудын зургийг хайчлаад бөмбөлөг дээрээ наагаарай.

2.33 дугаар зураг. Бөмбөлөг наах

ЦААСЫГ НУГАЛЖ ХАЙЧЛАХ АРГААР ТОГЛООМ ХИЙХ




Хэрэглэгдэхүүн: Өнгийн цаас, харандаа, цаасны цавуу, хайч, эсгий бал



Тасархай зураасын дагуу нугална.



1



2



2.34 дүгээр зураг. Эрвээхэй хийх арга

- Эрвээхэйн далавчийг өөрийн сонирхлоор зурж чимэглээрэй.
- Эрвээхэйн далавчийг хавсарч нийлүүлэн нугална.
- Зурагт үзүүлснээр доош татахад далавч дэвж нисэх мэт хөдөлгөөн хийнэ.

Сонгох даалгавар. Соно, шувуу



2.35 дугаар зураг. Цаасан тоглоомууд



Хун

2.36 дугаар зураг. Шувуу хийх арга




2.37 дугаар зураг. Сурагчдын бүтээл

ЦААСЫГ НУГАЛЖ ХАЙЧЛАХ АРГААР МАШИН БҮТЭЭХ



Хийх дараалал:



2.38 дугаар зураг.

АМЬТНЫ ЗАГВАР ХИЙХ



Хэрэглэгдэхүүн: Гуаш, усан будаг, бийр, будгийн нийлүүр, өнгийн цаас, цавуу

Наймаалж хийх аргачлал:



1. Аяганы амсрыг зураг дээрхтэй адил хайчилна.



2. Хайчилсан хэсгүүдийг гадагш эргүүлэн цэцгийн дэлбээ шиг хэлбэрт оруулна.



3. Амсрыг нь гуашаар будна.



4. Нүд, амыг өнгийн цаас ашиглан хийгээд наагаарай.

2.39 дүгээр зураг. Наймаалж хийх арга

ЦААС НУГАЛЖ БҮТЭЭЛ ХИЙХ





Цэцэг хийцгээе.

Хэрэглэгдэхүүн:




Өнгийн цаас, хайч, цавуу, эсгий бал

Тасархай зураасын дагуу нугална.



Зургийн дагуу нугалаарай




2.40 дүгээр зураг. Цэцэг хийх




Цэцгээ чимэглэж зураарай




Цэцэг, навч хийх



2.41 дүгээр зураг. Яргуй хийх



Эрээн цоохор эрвээхэй




2.42 дугаар зураг. Цоохор эрвээхэй



Эрвээхэйн загвар зохиож нугалаад чимэглээрэй.



Цаас нугалж ямаа бүтээе.




2.43 дугаар зураг. Цаас нугалж хийсэн ямаа




2.44 дүгээр зураг. Цаас нугалж хийсэн зохиомж



1



2



2.45 дугаар зураг. Цаас нугалж хувцас хийцгээе



2.46 дугаар зураг. "Ямаачин хүүхдүүд"

НАВЧААР УРЛАХ



1



2



3



2.47 дугаар зураг. Навчин загас

Хатсан навч ашиглан багаараа мод урлаарай.

Хэрэглэгдэхүүн




2.48 дугаар зураг. Улиас мод




Тосон харандаагаар навч зураад будаарай. Зурсан навч дээгүүр бичгийн цавуу түрхээрэй.

2.49 дүгээр зураг. Навчаар загас хийх



2.50 дугаар зураг. Навчин туулай

Туулай, цэцэг хоёрын аль нэгийг нь сонгон урлаарай.



2.51 дүгээр зураг. Навчаар хийсэн цэцэг



Навчны өнгө яагаад өөрчлөгдөж байдгийг эцэг эхтэйгээ ярилцаарай.

БАРИМЛЫН ШАВРААР УРЛАХ



Хэрэглэгдэхүүн:



Нойтон алчуур

Баримлын шаврын доор тавих зүйл



Нойтон алчуураар юу хийж байна вэ? Хуванцар хутгаар юу хийж байна вэ?




Баримлын шаврыг хавтгайлах, хэвлэх аргаар хагас товгор дүрс бүтээгээрэй.



Хавтгайлах



Хэв



Хэвлэсэн дүрс



Хэвлэх аргаар урласан дүрсүүдийг ажиглаарай.



2.52 дугаар зураг.



Баримлын шаврыг цувих, хэрчих, бөөрөнхий



Цувих




Хэрчих



Бөөрөнхийлөх




Холбох аргаар жимс, ногоо хийгээрэй.



2.53 дугаар зураг. Жимс, ногоо



Баримлын шавраар луувангийн дүрс хийгээрэй.



ЧАГТАН ХЭЭГ БАРИМЛЫН ШАВРААР ХИЙХ


Хэрэглэгдэхүүн:



2.54 дүгээр зураг. Чагтан хээ



2.55 дугаар зураг. Ширмэл ширдэг дээрх чагтан хээ



2.56 дугаар зураг. Өнгийн цаасаар наасан чагтан хээ



2.57 дугаар зураг. Баримлын шавраар хийсэн чагтан хээнүүд



2.58 дугаар зураг. Зургийг дэвтэртээ хуулж зураад, чагтан хээгээр чимэглээрэй.



Баримлын шавраа гялгар уутнаас гаргаад удаан байлгавал амархан хатдаг.



Гэрийнхэндээ баримлын шавраар чагтан хээ хийж үзүүлээрэй.

АШИГЛАСАН НОМ

1. Баярмаа Ч. (2009). Монгол ардын хээ угалз. Улаанбаатар
2. Даваахүү С. (2007). Уураг тархи ба шинжлэх ухаан. Улаанбаатар
3. Дэлгэрмаа Б. (2002). Урлаг ба танин мэдэхүйн онолын харилцааны асуудал. Нэг сэдэвт зохиол. Улаанбаатар
4. Лхагва А. (2009). Монгол зураачид. Улаанбаатар
5. Манибатар Д. (2012). Монгол үндэсний хээ угалз. Улаанбаатар
6. Санжжав Д. Энхболд С. (2000). “Сэтгэл судлалын ухааны тайлбар толь.” Улаанбаатар
7. Солсо Р.Л. (1996). Когнитивная психология. Москва.
8. Сономцэрэн Л. (1987). Дүрслэх урлагийн онол, түүхийн асуудлууд Улаанбаатар
9. Сономцэрэн Л. (1971). Монголын эртний дүрслэх урлаг. Улаанбаатар
10. Цойгнер Г. (1971). Учение о цвете. Москва.
11. Цэвээндорж Д. (1999). Монголын эртний урлагийн түүх. Улаанбаатар
12. Цэдэн-Иш Д. (2007). Сурагчдын зурах дүрслэх чадварын хөгжлийн судалгаа. Улаанбаатар
13. Цэдэн-Иш Д. (2011). Дүрслэх урлагийн багшийн ном. Улаанбаатар
14. Цүлтэм Н. (1988). Монголын уран зураг хөгжиж ирсэн тойм. Улаанбаатар
15. Эрдэнэцог Ц. (1999). Уран зургийн өнгө. Улаанбаатар
16. Эрдэнэцог Ц. (2007). XX зууны Монголын уран зургийн өнгө зохирол. Улаанбаатар
17. Editor Uranchimeg Ts. (2000). Union of Mongolian artists
18. Enkhjin Ts. (2010). Union of Mongolian artists
19. Жои Эванс, Тая Скелтон (2009). Дүрслэх урлаг. Улаанбаатар

ДҮРСЛЭХ УРЛАГ, ТЕХНОЛОГИ I

Ерөнхий боловсролын сургуулийн
1 дүгээр ангийн сурах бичиг

Зохиогчийн баг

Ахлагч:	Д.Цэдэн-Иш
Гишүүд:	Т.Ариунаа Ч.Мөнхтуяа Б.Мөнхжаргал
Редактор:	С.Нямсүрэн
Техник редактор:	С.Лувсанвандан
Зураач:	Ц.Мөнхмандах
Хэвлэлийн эх бэлтгэгч:	С.Оюунбат
Засварласан баг:	Д.Хөхөө С.Отгонтуяа П.Болдбаатар
Хэвлэлийн дизайнер:	Г.Ганчимэг

Формат 84x108/16
Офсет хэвлэл. Офсет хэвлэлийн цаас. 80 гр/м²
Хэвлэлийн хуудас 8 х.х.

Хэвлэлийн эхийг “Гоо Дизайн” ХХК-д бэлтгэж,
“Соёмбо принтинг” ХХК-д 78000 хувь хэвлэв.